



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 11 сарын 29-ны өдрийн "Заавар батлах тухай" 537 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 2.4.1 дүгээр зүйл, нийслэлийн Өргөө амаржих газрын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой хийсэн хамтын гэрээний 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амаржих газрын эмч, эмнэлгийн ажилтнуудыг 2020.06.03-2020.12.01 хооронд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсугай.

2. Эмч, эмнэлгийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах хуваарийг нэгдүгээр, шинжилгээнд хэрэглэгдэх эрүүл мэндийн хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ажилтны эрүүл мэндийн хуудсыг нэгтгэн эмнэлгийн ажилтнуудын цахим мэдээний сан бүрдүүлэхийг Халдварын сэргийлэлт, хяналтын алба /Б.Халиунаа/-д, шинжилгээний хариунд дүгнэлт хийн, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Дотрын эмч /Т.Байгальмаа/-д, урьдчилан сэргийлэх ажилд тасаг, хэсгийн ажилтнуудыг бүрэн хамруулахыг тасгийн эрхлэгч, хэсгийн ахлагч, арга зүйч эх баригч, арга зүйч сувилагч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Үзлэг, шинжилгээнд шаардлагатай оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж ажиллахыг эмийн сангийн эрхлэгч /Э.Золжаргал/-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан /Ц.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА




АДУҮРЭНБИЛЭГ

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
 А/40 дугаар тушаалын нэгдүгээр хэвсрэлт

Эмч, эмнэлгийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэг,
 шинжилгээнд хамрагдах хуваарь

№	Хэсэг, нэгж	Хийгдэх шинжилгээ	Үзлэгт хамрагдах өдөр	Үзлэгт хамрагдах цаг
1	Эх барих тасаг /ТХ, ТДХ, МЗДХ/	1. ХДХВ 2. HBsAg 3. Anti HBs 4. Anti HCV 5. MRSA	2020.06.03	08 ³⁰ -11 ⁰⁰
2	Эх барих тасаг /ХАЖЭЭХ, ДТЭЭХ, АХ/		2020.06.04	08 ³⁰ -11 ⁰⁰
3	Эх барих тасаг /МЗМЭЭХ/		2020.06.08	08 ³⁰ -11 ⁰⁰
4	Амбулатори, эмийн сан, онош зүй		2020.06.10	08 ³⁰ -11 ⁰⁰
5	Нярайн тасаг		2020.06.11	08 ³⁰ -11 ⁰⁰
6	Эмэгтэйчүүдийн тасаг		2020.06.15	08 ³⁰ -11 ⁰⁰
7	Захиргаа, Дэмжих хэсэг		2020.07.20	08 ³⁰ -11 ⁰⁰
8	Бүх тасаг хэсгийн эмч эмнэлгийн ажилтнууд	1. Цэвж гэрэлд харах 2. ЭХО	2020.12 сар дотор	08 ³⁰ -14 ⁰⁰

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
А/4 дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт



Ажилтны эрүүл мэндийн хуудасны загвар

1. Овог _____
4. Нас _____
5. Албан тушаал: _____

2. Нэр _____
4. Хүйс: Эр Эм

А. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ (Жил бүр ЭМА үзлэг, шинэ ажилтанд)

Шинжилгээний төрөл	Үр дүн	Он сар өдөр	Эмнэлэг, лабораторийн нэр	Эмчийн гарын үсэг
Цээж гэрэлд харах				
ХДХВ				
HBsAg				
Anti HBs				
Anti HCV				
MRSA				

Б. Дархлаажуулалт (Шинэ ажилтанд)

Баталгаажуулах	Дархлаажуулалтад хамрагдсан хугацаа он, тун	Эсрэг бие тодорхойлуулсан эсэх
		Тийм/Үгүй
Гепатит В: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		
Сахуу, хөхүүл ханиад, татран: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		
Улаанбурхан, гахай хавдар, улаанууд: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		

В. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн дүгнэлт:

_____ Гарын үсэг